



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

XXVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 10:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-д 77 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, эрүүл мэндийн байгууллагын хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд

2. Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, вакцинжуулалтын талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан

3. Бусад /Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар/

Боловсрол, шинжлэх ухааны сайд
Улсын онцгой комиссын гишүүн Л.Энх-Амгалан

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаанд:

1.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэлтийн бодис, хамгаалах хувцас хэрэглэлийн шаардлагатай нөөцийг тогтмол бүрдүүлэх, коронавирусын халдвар (Ковид-19) авсан иргэдийг тусгаарлан эмчлэх эмнэлгийн ор, тусгаарлан эмчлэх байр, эмч, эмнэлгийн ажилтнуудын бэлэн байдлыг хангах;

1.2. Олон улсад Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглаж байгаа шинэ төрлийн сүүлийн үеийн эм, тариа, судалгааны ажлын явцын талаар нэгдсэн мэдээлэл боловсруулж 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

1.3. Халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан эмчилгээний явуулын баг, тандалтын багийн хүн хүчний тоог нэмэгдүүлэх, эрэмбэлэн ангилалтыг оновчтой зохион байгуулж эмчилгээний чанар, эмнэлгийн орны эргэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах;

1.4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 55-аас дээш насны иргэд, боловсролын байгууллагын багш, ажилтан, эрсдэлт бүлгийн иргэд, хариу арга хэмжээний багийн гишүүд болон хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг вакцины нэмэлт тунд хамруулах ажлыг эрчимжүүлэх;

1.5. Хилийн боомтод ажиллаж буй алба хаагчид, хилээр бүх төрлийн бараа, бүтээгдэхүүн, ачаа, түүхий эд тээвэрлэхэд оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, хувь хүмүүсийг коронавирусын халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунд хамруулах, халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. “Хариуцлагын гэрээ” байгуулан үйл ажиллагааг нь нээсэн хуулийн этгээдүүд хууль, журамд заасан шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулж, халдвар хамгааллын дэглэм мөрдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, зөрчсөн аж ахуйн нэгж байгууллагуудад хуульд заасан арга хэмжээ авч, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

3.1. Баян-Өлгий, Дундговь, Өвөрхангай, Ховд зэрэг зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан өвчний голомтыг хяналтад авах, өвчний тархалтыг зогсоох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх, өвчлөмтгий малыг вакцинжуулах ажлыг зохион байгуулах;

3.2. Шүлхий өвчин гарсан аймаг, сумдад мэргэжлийн баг томилон ажиллуулж, халдварыг зогсоох арга хэмжээ авах;

3.3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөмтгий малыг дархлаажуулахад шаардагдах вакцины нөөц бүрдүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Цэцэрлэг, сургуулийн орчинд хууль, журамд заасан шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулж, халдвар хамгааллын дэглэм мөрдөх, түүнд хяналт тавьж, биелэлтийг хангахад эцэг, эх, асран хамгаалагч, багш, сургууль, цэцэрлэгийн захиргаа болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.2. Цэцэрлэг, сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэм мөрдөх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилган халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэд:

5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй гар утасны болон бусад программын хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаанд:

6.1. Экспорт, импортын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хилийн Замын-Үүд боомтын бүсэд “Ногоон бүс” бий болгоход шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, холбогдох тооцоо, судалгааг хийж тусгаарлах байр бий болгох;

Долоо. Улсын онцгой комиссын гишүүн, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзулд:

7.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглаж байгаа эм, тарианы аюулгүй, зөв хэрэглээ болон буруу хэрэглээнээс үүдэн гарах гаж нөлөө, хор уршгийн талаар олон нийтэд мэдээ, мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ